

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/78/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/78/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Е.БАРШАГУЛ ТАНАА

2024.02.08 № 51
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 3,641.9 сая төгрөгийн өртөгтэй цэцэрлэгийн шинэ барилгыг ашиглалтад хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402062

Өлгий 1-р цэцэрлэг Дүгнэлт

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ



Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53446157.52	147625901.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14073928.00	90144867.00
31211	Төрийн сангийн харилцах	14073928.00	90144867.00
33	АВЛАГА	1625500.00	1625500.00
3351	Байгууллагаас авах авлага	1625500.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37746729.52	57481034.52
35420	Аж ахуйн материал	501600.00	501600.00
35460	Хүнсний материал	4121619.52	5519124.52
35470	Бусад хангамжийн материал	33123510.00	51460310.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	867751752.19	3761825144.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	867751752.19	3761825144.08
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	831091752.19	3723741905.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.00	3641917893.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35307316.00	39815326.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17447178.41	-19381907.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37809864.00	84715068.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-29631249.40	-25564074.36
39216	Дуусаагүй барилга, байгууламж	802813400.00	0.00
39217	Ном	2239600.00	2239600.00
393	Биет бус хөрөнгө	36660000.00	38083239.00
39301	Програм хангамж	275000.00	1698239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275000.00	-275000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36660000.00	36660000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	921197909.71	3909451045.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	4995064.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	4995064.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	921197909.71	3904455981.60
51	Засгийн газрын хувь оролцоо	921197909.71	3904455981.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	114553159.00	114553159.00
51101	Өмч: - төрийн	114553159.00	114553159.00
512	Хуримтлагдсан үр дүн	806644750.71	3789902822.60
51210	Өмнөх үеийн үр дүн	806644750.71	806644750.71
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	2983258071.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	921197909.71	3909451041.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,454,283,700.00	3,848,420,322.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	804,513,400.00	2,913,544,722.00

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	802,813,400.00	2,900,744,722.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,700,000.00	12,800,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	532,999,300.00	846,611,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	532,999,300.00	846,611,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,667,500.00	88,264,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,667,500.00	88,264,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	635,594,497.23	865162250.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635,594,497.23	865162250.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635,594,497.23	865162250.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426,488,217.00	568,515,486.00
210101	Үндсэн цалин	350,377,617.00	380,926,964.00
210102	Нэмэгдэл	64,751,800.00	169,515,622.00
210104	Урамшуулал	11,358,800.00	18,072,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,553,900.00	84,679,500.00
210201	Тэтгэврийн даатгал	36,546,900.00	57,420,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,251,900.00	6,813,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,401,300.00	5,452,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	850,500.00	1,363,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,503,300.00	13,629,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,714,100.00	94884564.00
210301	Гэрэл, цахилгаан	4,901,100.00	5716000.00
210302	Түлш, халаалт	65,600,000.00	6310564.00
210303	Цэвэр, бохир ус	6,213,000.00	6358000.00
210304	Байрны түрээс	-	76,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
2105	Нормативт зардал	59,680,325.00	93,107,070.00
210502	Хоол, хүнс	59,680,325.00	93,107,070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	536,100.00	1,468,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	536,100.00	1,468,600.00

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,518,355.23	22,507,030.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,060,170.00	12,040,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,344,460.00	3,795,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,113,725.23	6,671,330.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	818,689,202.77	2983258071.89
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	818,689,202.77	2983258071.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	649770300.00	934875600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	532999300.00	846611600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	532999300.00	846611600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116667500.00	88264000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116667500.00	88264000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	635696372.00	858804661.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635696372.00	858804661.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634520772.00	858804661.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	426488217.00	568515486.00
210101	Үндсэн цалин	350377617.00	380926964.00
210102	Нэмэгдэл	64751800.00	169515622.00
210104	Урамшуулал	11358800.00	18072900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53553900.00	84679500.00
210201	Тэтгэврийн даатгал	36546900.00	57420700.00
210202	Тэтгэмжийн даатгал	4251900.00	6813900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3401300.00	5452200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	850500.00	1363300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8503300.00	13629400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76714100.00	88264000.00
210301	Гэрэл, цахилгаан	4901100.00	5551000.00
210302	Түлш, халаалт	6560000.00	
210303	Цэвэр, бохир ус	6213000.00	6213000.00
210304	Байрны түрээс		7650000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103500.00	0.00
210401	Бичиг хэрэг	103500.00	
2105	Нормативт зардал	62369825.00	94504575.00
210502	Хоол, хүнс	62369825.00	94504575.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	536100.00	1468600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	536100.00	1468600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14755130.00	21372500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10447100.00	16949700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4308030.00	4422800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1175600.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1175600.00	

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14073928.00	76070939.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	14073928.00	76070939.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		14073928.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14073928.00	90144867.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,553,159.00		806,644,750.71		921,197,909.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,553,159.00	0.00	806,644,750.71	0.00	921,197,909.71
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,553,159.00	0.00	806,644,750.71	0.00	921,197,909.71
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,553,159.00	0.00	806,644,750.71	0.00	921,197,909.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,553,159.00	0.00	806,644,750.71	0.00	921,197,909.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			2,983,258,071.89		2,983,258,071.89
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,553,159.00	0.00	3,789,902,822.60	0.00	3,904,455,981.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		14073928.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	948949528.00	858804661.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	948949528.00	858804661.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	948949528.00	858804661.00

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	649743253.00	568515486.00
210101	Үндсэн цалин	432965700.00	380926964.00
210102	Нэмэгдэл	198704653.00	169515622.00
210104	Урамшуулал	18072900.00	18072900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86152400.00	84679500.00
210201	Тэтгэврийн даатгал	58422300.00	57420700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6931700.00	6813900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5546500.00	5452200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1386900.00	1363300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13865000.00	13629400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88264000.00	88264000.00
210301	Гэрэл, цахилгаан	5551000.00	5551000.00
210302	Түлш, халаалт		
210303	Цэвэр, бохир ус	6213000.00	6213000.00
210304	Байрны түрээс	76500000.00	76500000.00
2105	Нормативт зардал	101901675.00	94504575.00
210502	Хоол, хүнс	101901675.00	94504575.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1474300.00	1468600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1474300.00	1468600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21413900.00	21372500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16991100.00	16949700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4422800.00	4422800.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	934875600.00	934875600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	846611600.00	846611600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	846611600.00	846611600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	88264000.00	88264000.00
132001	Орон нутгийн төсвөөс	88264000.00	88264000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		14073928.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		90144867.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	42.00
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.0	25.0
620003	Үйлчлэх ажилтан	16.0	16.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42.0	42.0
650004	СЕБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	25.00	25.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг.

Цэцэрлэг нь “Бид хүүхдийн эрхийг дээдлэн, тэгш хэрэгцээ, хүсэл сонирхлыг нь эрхэмлэн, тоглонгоо хөгжүүлж сургуульд бэлтгэнэ” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллаасан байна.

- Хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх,
- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх,
- Хүүхдүүдийн хүсэл сонирхлыг дээдлэн цогцоор нь хөгжүүлэх,
- Сургуульд бэлтгэх

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийгдээгүй байна.

Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2988.3 сая төгрөгөөр буюу 324.5 хувиар өссөн байна.

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14073.9	90144.9	76071.0
Авлага	1625.5	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	37746.7	57481.0	19734.3
Үндсэн хөрөнгө	867751.7	3761825.1	2894073.4
Нийт хөрөнгө	921197.9	3909451.1	2983258.1
Өр төлбөр	0	4995.1	-4995.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	921197.9	3904456.0	2983258.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	921197.9	3904456.0	2983258.1

Мөнгөн хөрөнгө оны эцэст 90.1 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 76.1 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 82.7 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс, 7.4 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлаас үлдсэн мөнгө байна.

Авлага дансанд бүртгэлтэй байсныг 1.6 сая төгрөгийн он дамжсан бусад зардлын тооцооны авлагыг данснаас хассан байна.Энэ нь цэцэрлэгийн шинэ барилгын техникийн нөхцөлд тогтмол зардлаас төлсөн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 57.5 сая төгрөг болж оны эхнээс 19.7 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: хүнсний материал 5.5 сая төгрөгийн, бусад хангамжийн материал 51.5 сая төгрөгийн, аж ахуйн материал 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2894.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 2900.7 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгөд 6.7 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эцэст 5.0 сая төгрөгийн өглөгтэй гарсан нь түлш халаалт, бусад тооцооны өглөг байна.Энэ нь цэцэрлэгийн шинэ барилгад орсонтой холбоотой гарсан халаалтын зардлын хүрэлцээгүйгээс гарсан өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2984.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2983.3 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 544.6 сая, орон нутгийн төсвөөс 88.3 сая, нийт зарлагыг 632.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 624.5 сая төгрөгөөр хянаж, 79.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 222.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 846.6 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 88.3 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 846.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 88.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 934.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 846.6 сая, орон нутгийн төсвөөс 88.3 сая нийтдээ 934.9 сая төгрөгийн санхүүжилт авч, 14.1 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 858.8 сая төгрөг буюу 90.5 хувьтай буюу дансанд 90.1 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	2211.4	2211.4	0	100%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	101901.7	94504.6	7397.1	92.7%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	4607.1	4607.1	0	100%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	2211.4	2170.0	41.4	98.1%
5	Боловсролын стандарт, сургалтын	550568.8	467862.4	82706.4	84.9%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	199185.2	199185.2	0	100%
7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	88264.0	88264.0	0	100%
	Нийт дүн	948949.6	858804.7	90144.9	90.5%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 90.1 сая төгрөгийн бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 81.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1.5 сая, нормативт зардал 7.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгт 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 110.1 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 636.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 12.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 14.7 сая төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 75 хувьтай гарсан зөрчилд холбоотой албан шаардлага өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	14691.0	1	14691.0	100%
Зөвлөмж					
Нийт дүн	1	14691.0	1	14691.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар 19.1 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 19.1 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Өлгий сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн	1	19,100.0					1	19,100.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								